



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/10/СТА-ТТЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 99014227
Цахим хаяг: daqvasurenb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330
Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Аудитор Ц.Оюунсүвд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

догол. 03.05 № 1302/467

танай _____ -ны № _____ -т

ОТГОН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ж.АМГАЛАНБАЯР-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Отгон сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Audit(D)A4-тоот/2022

01302553

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>493,382,789.64</u>	<u>637,439,523.37</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	127,528,508.26	287,555,301.13
312	Банканд байгаа бэлэн мөнгө	127,528,508.26	287,555,301.13
3121	Төгрөг	127,528,508.26	287,555,301.13
31211	Төрийн сангийн харилцах	127,528,508.26	287,055,301.13
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	500,000.00
33	АВЛАГА	167,605,974.26	151,621,126.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	693,619.26	3,754,403.52
335	Бусад авлага	166,912,355.00	147,866,723.00
3351	Байгууллагаас авах авлага	529,992.00	16,999,992.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	166,382,363.00	130,866,731.00
35	БАРАА МАТЕРИАЛ	198,248,307.12	198,263,095.72
351	Түүхий эд материал	47,422,626.63	56,116,516.63
35110	Тусгай зориулалттай материал	43,422,451.46	52,943,741.46
35130	Эм боох материал	4,000,175.17	3,172,775.17
354	Хангамжийн материал	150,825,680.49	142,146,579.09
35410	Бичиг хэргийн материал	2,279,400.00	2,764,610.00
35420	Аж ахуйн материал	19,429,765.00	20,764,995.00
35430	Сэлбэг хэрэгсэл	77,500.00	478,000.00
35440	Түлш, шатах тослох материал	22,159,160.00	11,375,996.00
35450	Барилгын засварын материал	4,347,400.00	2,172,400.00
35460	Хүнсний материал	24,479,150.00	12,100,120.00
35470	Бусад хангамжийн материал	78,053,305.49	92,490,458.09
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,695,517,674.31</u>	<u>2,590,446,202.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,695,517,674.31	2,590,446,202.51
392	Биет хөрөнгө	2,604,768,674.31	2,500,844,702.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,560,030,433.63	2,559,371,705.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(337,111,236.45)	(442,105,419.33)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	252,721,474.00	294,371,474.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(115,738,837.06)	(143,261,929.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	521,822,960.60	561,412,218.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(401,993,399.47)	(453,572,276.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	193,787,902.96	197,344,451.19
39208	Хуримтлагдсан элэгдэл	(145,485,924.48)	(153,488,163.36)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,072,300.00	2,082,300.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	103,427,828.52	99,261,768.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	(77,563,764.92)	(74,322,378.45)
39217	Ном	48,798,936.98	53,750,951.98
393	Биет бус хөрөнгө	90,749,000.00	89,601,500.00
39301	Программ хангамж	8,687,000.00	8,687,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,062,000.00)	(4,209,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	85,124,000.00	85,124,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,188,900,463.95</u>	<u>3,227,885,725.88</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,188,900,463.95</u>	<u>3,227,885,725.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,188,900,463.95	3,227,885,725.88

**Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,806,080,891.33	1,806,080,891.33
51101	Өмч: - төрийн	1,806,080,891.33	1,806,080,891.33
512	Хуримтлагдсан үр дүн	890,813,002.68	930,346,592.61
51210	Өмнөх үеийн үр дүн	775,833,607.56	895,532,298.68
51220	Тайлант үеийн үр дүн	114,979,395.12	34,814,293.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	492,006,569.94	491,458,241.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,188,900,463.95</u>	<u>3,227,885,725.88</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,015,722,323.08	3,078,721,541.25
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,678,886.16	112,109,580.20
110	Орлогын албан татвар	37,933,488.16	26,021,202.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	37,933,488.16	26,021,202.20
110002	Үйл ажиллагааны орлого	31,423,055.54	22,581,202.20
110003	Хөрөнгийн орлого		100,000.00
110008	Шууд бус орлого	6,510,432.62	3,340,000.00
113	Хөрөнгийн албан татвар	2,950,000.00	2,479,500.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	550,000.00	600,000.00
113002	Бууны албан татвар	2,400,000.00	1,819,000.00
113004	Малд ногдуулах албан татвар		60,500.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,795,398.00	83,608,878.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,508,140.00	843,680.00
118001	Улсын тэмдэгийн хураамж	338,140.00	813,680.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	820,000.00	
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	350,000.00	30,000.00
1181	Газрын төлбөр	87,258.00	657,998.00
118101	Газрын төлбөр	87,258.00	657,998.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	200,000.00	81,907,200.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		81,907,200.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	110,000.00	
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	90,000.00	
1183	Бусад татвар	-	200,000.00
118301	Бусад татвар		200,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	268,616,105.47	157,815,899.46
120	Нийтлэг татварын бус орлого	268,616,105.47	157,815,899.46
120002	Хүүгийн орлого	25,230,687.96	34,254,954.30
120003	Торгуулийн орлого	1,219,500.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	236,430,431.51	121,197,245.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	153,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	236,277,431.51	121,197,245.16
120009	Бусад орлого	5,735,486.00	2,063,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,704,427,331.45	2,808,796,061.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,425,684,800.00	1,461,685,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,425,684,800.00	1,461,685,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,054,737.00	215,335,965.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,627,284.00	20,247,025.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,427,453.00	195,088,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,167,989,994.45	1,105,406,355.95
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	584,736,800.00	530,812,000.00

**Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	1,352,716.45	246,280.95
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	509,504,700.00	476,371,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72,395,778.00	97,976,175.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,697,800.00	26,368,140.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,697,800.00	26,368,140.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,805,888,394.78	2,979,573,756.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,805,888,394.78	2,979,573,756.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,099,291,509.84	2,320,582,120.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,382,159,838.56	1,460,530,988.00
210101	Үндсэн цалин	1,009,685,025.19	993,606,718.93
210102	Нэмэгдэл	259,405,324.00	332,781,218.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,058,000.00	5,095,000.00
210104	Урамшуулал	90,753,761.00	112,420,551.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,257,728.37	16,627,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,703,882.70	194,619,520.32
210201	Тэтгэврийн даатгал	125,485,882.70	135,717,505.52
210202	Тэтгэмжийн даатгал	14,479,300.00	14,712,703.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,583,500.00	11,770,282.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,196,700.00	3,002,421.21
210205	Эрүүл мэндийн даатгал	28,958,500.00	29,416,606.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,668,363.55	121,186,324.05
210301	Гэрэл, цахилгаан	13,889,366.55	12,188,606.05
210302	Түлш, халаалт	112,447,997.00	106,488,718.00
210303	Цэвэр, бохир ус	331,000.00	2,509,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,230,830.00	76,412,361.64
210401	Бичиг хэрэг	7,927,450.00	10,716,943.64
210402	Тээвэр, шатахуун	41,492,100.00	48,979,148.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,489,500.00	5,287,350.00
210404	Ном, хэвлэл	17,900.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,800.00	699,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,747,930.00	4,728,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,983,150.00	6,001,320.00
2105	Нормативт зардал	69,378,091.94	104,308,214.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,987,076.94	56,946,514.00
210502	Хоол, хүнс	37,256,015.00	47,009,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	135,000.00	352,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,476,935.00	6,428,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,700,000.00	
210604	Урсгал засвар	4,776,935.00	6,428,400.00
2107	Томилолт, зочны зардал	6,738,300.00	20,399,300.00
210702	Дотоод албан томилолт	6,738,300.00	20,399,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,251,336.00	27,461,303.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,796,451.00	24,738,165.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	523,100.00	1,877,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	289,205.00	524,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	286,200.00	92,085.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	80,000.00
210807	Газрын төлбөр	138,180.00	94,103.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,683,932.09	309,235,709.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,819,886.00	93,825,096.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,292,000.00	6,674,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,572,046.09	208,736,153.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	706,596,884.94	658,991,635.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,584,784.00	68,757,692.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		22,985,430.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,631,500.00	

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,453,284.00	13,412,262.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	32,360,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	586,096,716.45	554,372,443.95
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	584,736,800.00	530,812,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,352,716.45	8,446,280.95
213404	Хөрөнгийн	7,200.00	15,114,163.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,915,384.49	35,861,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,915,384.49	35,861,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>209,833,928.30</u>	<u>99,147,785.13</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	94,854,533.18	64,333,491.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,833,333.18	263,491.20
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	84,021,200.00	64,070,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(94,854,533.18)	(64,333,491.20)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>114,979,395.12</u>	<u>34,814,293.93</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,806,080,891.33	492,006,569.94	780,761,073.56	3,078,848,534.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-4,927,466.00	-4,927,466.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,806,080,891.33	492,006,569.94	775,833,607.56	3,073,921,068.83
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	114,979,395.12	114,979,395.12
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,806,080,891.33	492,006,569.94	890,813,002.68	3,188,900,463.95
D01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,806,080,891.33	492,006,569.94	890,813,002.68	3,188,900,463.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,719,296.00	4,719,296.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,806,080,891.33	492,006,569.94	895,532,298.68	3,193,619,759.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-548,328.00	0.00	-548,328.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	34,814,293.93	34,814,293.93
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,806,080,891.33	491,458,241.94	930,346,592.61	3,227,885,725.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,859,390,191.57</u>	<u>3,010,270,896.09</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,678,886.16	112,109,580.20
110	Орлогын албан татвар	37,933,488.16	26,021,202.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	37,933,488.16	26,021,202.20
110002	Үйл ажиллагааны орлого	31,423,055.54	22,581,202.20
110003	Хөрөнгийн орлого		100,000.00
110008	Шууд бус орлого	6,510,432.62	3,340,000.00
113	Хөрөнгийн албан татвар	2,950,000.00	2,479,500.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	550,000.00	600,000.00
113002	Бууны албан татвар	2,400,000.00	1,819,000.00
113004	Малд ногдуулах албан татвар		60,500.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,795,398.00	83,608,878.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,508,140.00	1,043,680.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	338,140.00	813,680.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	820,000.00	
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	350,000.00	30,000.00
118011	Бусад татвар (төлбөр, хураамж)		200,000.00
1181	Газрын төлбөр	87,258.00	657,998.00
118101	Газрын төлбөр	87,258.00	657,998.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	200,000.00	81,907,200.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		81,907,200.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	110,000.00	
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	90,000.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,180,973.96	105,305,254.30
120	Нийтлэг татварын бус орлого	112,180,973.96	105,305,254.30
120002	Хүүгийн орлого	20,245,887.96	27,169,595.30
120003	Торгуулийн орлого	1,219,500.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,355,486.00	77,815,259.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,355,486.00	77,815,259.00
120009	Бусад орлого	360,100.00	20,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,704,530,331.45	2,792,856,061.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,425,684,800.00	1,461,685,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,425,684,800.00	1,461,685,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,157,737.00	215,335,965.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,730,284.00	20,247,025.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,427,453.00	195,088,940.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,167,989,994.45	1,105,406,355.95
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	584,736,800.00	530,812,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	1,352,716.45	246,280.95
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	509,504,700.00	476,371,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72,395,778.00	97,976,175.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,697,800.00	10,428,140.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	15,697,800.00	10,428,140.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,655,937,487.00</u>	<u>2,731,529,103.22</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,655,937,487.00	2,731,529,103.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,894,187,552.06	2,076,419,897.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,381,985,313.51	1,460,029,975.58
210101	Үндсэн цалин	1,004,942,610.95	993,255,629.51
210102	Нэмэгдэл	264,523,080.19	332,781,218.07

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,058,000.00	5,095,000.00
210104	Урамшуулал	90,203,894.00	112,424,539.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,257,728.37	16,473,589.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,279,262.00	197,682,700.00
210201	Тэтгэврийн даатгал	126,061,262.00	139,116,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,479,300.00	14,643,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,583,500.00	11,715,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,196,700.00	2,929,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,958,500.00	29,278,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,046,083.55	113,947,998.05
210301	Гэрэл, цахилгаан	13,889,366.55	12,718,606.05
210302	Түлш, халаалт	103,763,817.00	98,720,392.00
210303	Цэвэр, бохир ус	392,900.00	2,509,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,038,260.00	68,637,703.64
210401	Бичиг хэрэг	7,588,650.00	9,435,413.64
210402	Тээвэр, шатахуун	47,790,240.00	45,666,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,626,300.00	6,216,450.00
210404	Ном, хэвлэл	17,900.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,053,300.00	1,240,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,961,870.00	6,079,030.00
2105	Нормативд зардал	75,026,982.00	96,400,114.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,260,282.00	56,119,114.00
210502	Хоол, хүнс	38,700,900.00	36,631,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,065,800.00	3,650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,520,535.00	9,351,520.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,462,100.00	4,243,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	456,600.00	454,120.00
210604	Урсгал засвар	6,601,835.00	4,653,900.00
2107	Томилолт, зочны зардал	6,738,300.00	20,399,300.00
210702	Дотоод албан томилолт	6,738,300.00	20,399,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,444,128.00	26,650,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,635,743.00	23,477,642.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	593,100.00	1,877,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,205.00	524,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	92,085.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	14,800.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	407,400.00	80,000.00
210807	Газрын төлбөр	115,660.00	94,103.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	22,520.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,780,888.00	83,319,806.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,050,988.00	74,327,306.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,729,900.00	8,992,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	717,077,734.94	655,109,205.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,065,634.00	64,875,262.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,480,850.00	19,103,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,631,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,453,284.00	13,412,262.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	32,360,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	586,096,716.45	554,372,443.95
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	584,736,800.00	530,812,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,352,716.45	8,446,280.95
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,200.00	15,114,163.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,915,384.49	35,861,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,915,384.49	35,861,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1	<u>203,452,704.57</u>	<u>278,741,792.87</u>

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	114,357,750.00	89,335,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	114,357,750.00	89,335,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	114,357,750.00	89,335,000.00
223001	Бусад хөрөнгө	84,021,200.00	64,070,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,336,550.00	25,265,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(114,357,750.00)	(89,335,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	59,250,000.00	29,380,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	59,250,000.00	29,380,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(59,250,000.00)	(29,380,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	74,517,154.57	160,026,792.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,683,553.69	127,528,508.26
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	127,528,508.26	287,555,301.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны	
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,059,122,499.06	2,221,621,300.00	2,060,288,356.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,935,851,299.06	2,035,670,500.00	1,966,838,356.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,907,238,949.06	2,015,407,500.00	1,946,575,356.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,381,985,313.51	1,459,567,400.00	1,450,766,385.58
210101	Үндсэн цалин	1,004,942,610.95	1,056,323,400.00	983,992,039.51
210102	Нэмэгдэл	264,523,080.19	287,524,400.00	332,781,218.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,058,000.00	6,066,000.00	5,095,000.00
210104	Урамшуулал	90,203,894.00	93,026,100.00	112,424,539.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,257,728.37	16,627,500.00	16,473,589.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,279,262.00	197,717,200.00	197,682,700.00
210201	Тэтгэврийн даатгал	126,061,262.00	139,310,600.00	139,116,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,479,300.00	14,601,600.00	14,643,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,583,500.00	11,681,400.00	11,715,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,196,700.00	2,920,400.00	2,929,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,958,500.00	29,203,200.00	29,278,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,046,083.55	120,504,600.00	113,947,998.05
210301	Гэрэл, цахилгаан	13,889,366.55	23,643,600.00	12,718,606.05
210302	Түлш, халаалт	103,763,817.00	94,123,700.00	98,720,392.00
210303	Цэвэр, бохир ус	392,900.00	2,737,300.00	2,509,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71,654,310.00	71,790,000.00	67,282,540.00
210401	Бичиг хэрэг	8,631,450.00	9,959,400.00	9,191,750.00
210402	Тээвэр, шатахуун	47,790,240.00	44,692,000.00	44,149,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,626,300.00	7,867,700.00	6,216,450.00
210404	Ном, хэвлэл	291,150.00	2,266,000.00	404,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,053,300.00	840,500.00	1,240,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,261,870.00	6,164,400.00	6,079,030.00
2105	Нормативд зардал	52,834,650.00	85,919,000.00	54,899,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,067,950.00	18,841,000.00	16,778,650.00
210502	Хоол, хүнс	38,700,900.00	63,005,600.00	34,471,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,065,800.00	4,072,400.00	3,650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,846,535.00	6,829,500.00	5,361,520.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,962,100.00	1,066,700.00	253,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	456,600.00	456,600.00	454,120.00
210604	Урсгал засвар	4,427,835.00	5,306,200.00	4,653,900.00
2107	Томилот, зочны зардал	6,738,300.00	9,572,000.00	8,951,300.00
210702	Дотоод албан томилот	6,738,300.00	9,572,000.00	8,951,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,135,595.00	22,000,000.00	15,088,803.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,481,210.00	18,354,500.00	11,915,665.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	593,100.00	2,139,500.00	1,877,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,205.00	524,500.00	524,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,700.00	148,500.00	92,085.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	69,800.00	55,000.00

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,253,400.00	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	115,660.00	188,200.00	94,103.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	22,520.00	45,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,718,900.00	41,507,800.00	32,594,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,350,200.00	24,479,400.00	16,255,860.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,368,700.00	17,028,400.00	16,338,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,612,350.00	20,263,000.00	20,263,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,612,350.00	20,263,000.00	20,263,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,480,850.00	19,103,000.00	19,103,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт			
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,631,500.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,160,000.00	1,160,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,021,200.00	115,950,800.00	64,070,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	64,021,200.00	115,950,800.00	64,070,000.00
223001	Бусад хөрөнгө	64,021,200.00	115,950,800.00	64,070,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	59,250,000.00	70,000,000.00	29,380,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	59,250,000.00	70,000,000.00	29,380,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,098,602,563.06	2,221,621,300.00	2,142,629,793.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,336,769,415.51	1,470,689,300.00	1,425,824,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,336,769,415.51	1,470,689,300.00	1,425,824,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	655,779,861.55	623,888,300.00	628,562,294.05
122005	Орон нутгийн төсвөөс	583,384,083.55	525,912,000.00	530,586,119.05
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72,395,778.00	97,976,300.00	97,976,175.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,697,800.00	27,069,200.00	10,428,140.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,697,800.00	27,069,200.00	10,428,140.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,355,486.00	99,974,500.00	77,815,259.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,355,486.00		77,815,259.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		99,974,500.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,659,578.00	-	80,139,642.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,139,642.00	-	162,481,078.42
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	29.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	6.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	127.00	128.00
620001	Удирдах ажилтан	4.00	14.00	14.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	75.00	79.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	35.00	32.00
620004	Гэрээт ажилтан		3.00	3.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	150.00	561.00	561.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	411.00	411.00

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

630001	Төрийн өмчит ЕБС		411.00	411.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	150.00	150.00	150.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	150.00	150.00	150.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.00	127.00	128.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.00	9.00	9.00
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	16.00	75.00	76.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.00	5.00	5.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан		3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	214,835,965.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	214,835,965.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	155,109,540.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	9,263,590.00
210101	Үндсэн цалин		9,263,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,760,063.64
210401	Бичиг хэрэг		243,663.64
210402	Тээвэр, шатахуун	-	1,516,400.00
2105	Нормативд зардал	-	41,500,464.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	39,340,464.00
210502	Хоол, хүнс	-	2,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	13,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		13,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	11,448,000.00
210702	Дотоод албан томилолт	-	11,448,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	11,561,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		11,561,977.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	66,575,446.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	60,031,446.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,544,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	44,612,262.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	44,612,262.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		13,412,262.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	31,200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,114,163.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		15,114,163.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	215,335,965.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	215,335,965.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	20,247,025.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		195,088,940.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		500,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгон сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 3/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа сахилга хариуцлагыг дээшлүүлэн, төрийн албан хаагчдын чадавхыг сайжруулах зорилго, чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын Засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжтэй бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын хэрэгжилт, Сум хөгжүүлэх сангийн эргийн төлөлт, сумын аюулгүй нөөцийн өвс тэжээлийн тооллого хийж, ЗДТГ-ын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 3,010.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 45.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 33.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 287.6 сая төгрөг болж өмнөх оноос 160.0 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 0.5 сая төгрөг нь сумын ЭМТ-ийн, 120.2 сая төгрөг нь СХС-ийн, 42.3 сая төгрөг нь ОНХС-ийн, 124.6 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлага дансны үлдэгдэл 151.6 сая төгрөг болж өмнөх оноос 16.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахлын улмаас сумын Эрүүл мэндийн төвд үүссэн авлагатай холбоотой байна.

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЗДТГ	199,039.00	43,305.33
2	ИТХ	50,680.79	214,813.25
3	ЭМТ	450,563.00	18,928,026.40
4	ЕБС	379,992.00	1,631,605.00
5	Соёлын төв	519,903.06	237,208.54
6	СХС	166,081,800.00	130,566,168.00
ДҮН		167,605,974.26	151,621,126.52

Бараа материал

Бараа материалын үлдэгдэл 198.3 сая төгрөг болж өмнөх оноос 0.02 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,590.5 сая төгрөг болж 105.1 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 3.227.9 сая төгрөг болж 39.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг батлахдаа 2.065.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 156.1 сая төгрөгөөр бууруулж 2,221.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,221.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,035.7 сая төгрөгийг урсгал зардалд, 115.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 70.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,470.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 525.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27,1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 98.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 99.9 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,425.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 530.6 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 10.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 98.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 77.8 сая төгрөг, нийт 2,142.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 79.0 сая төгрөг дутуу санхүүжсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 77.8 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7.8 сая төгрөгийн зээл нэмж төлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,060.3 сая төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 0.3 сая төгрөгийг сумын төсөвт, 35.9 сая төгрөгийг улсын төсөвт, 8.2 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 20.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 189.6 сая, нийт 215.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 214.8 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 15.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг түвшнээс бага тул зөрчилгүй санал, дүгнэлт өгсөн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс 142 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх хэсэгт 47.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг, 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Отгон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 47.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй байна.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс 142 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх хэсэгт 47.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг, 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дахь хэсэгт таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг, 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ЗДТГ	4	21.4	3	11.6					1	9.8
2	Эрүүл мэндийн төв	6	78.2	4	37.5					2	40.7
3	Соёлын төв	1	1.0							1	1.0
4	Ерөнхий боловсролын сургууль	3	6.9	1	0.6	2	6.3				
5	Төвлөрүүлэн захирагч	1	47.3							1	47.3
Дүн		15	154.8	8	49.7	2	6.3			5	98.8